



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/247-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр
Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/247-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	673,484,046.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	4,041,304.41
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	4,041,304.41
31210	Төгрөг	0.00	4,041,304.41
31211	Төрийн сангийн харилцах	0.00	4,041,304.41
33	АВЛАГА	0.00	569,522,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	569,522,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	99,920,742.32
35100	Түүхий эд материал	0.00	76,813,990.32
35130	Эм боох материал	0.00	76,813,990.32
35400	Хангамжийн материал	0.00	23,106,752.00
35420	Аж ахуйн материал	0.00	5,263,210.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,270,684.00
35460	Хүнсний материал	0.00	16,572,858.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	689,729,741.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	689,729,741.35
39200	Биет хөрөнгө	0.00	646,925,341.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	772,988,093.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-358,698,091.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	135,612,131.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-128,320,464.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	645,438,795.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-461,397,754.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	66,476,325.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-32,192,661.70
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	11,417,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-4,398,330.32
39300	Биет бус хөрөнгө	0.00	42,804,400.00
39301	Программ хангамж	0.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	42,804,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	1,363,213,788.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,222,435.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,222,435.00
41300	Өглөг	0.00	10,222,435.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	10,222,435.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	1,352,991,353.08
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	1,352,991,353.08
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	757,270,416.00
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	-1,076,614,137.25
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	-1,736,973,603.60
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	660,359,466.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	1,672,335,074.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	1,363,213,788.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	2,836,237,358.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	92,062,501.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	92,062,501.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	49,184,914.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	42,877,587.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	2,744,174,857.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,145,578,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	1,145,578,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	815,024,933.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,356,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	779,724,933.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	33,944,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	151,477,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	151,477,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	632,093,424.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	632,093,424.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	2,175,877,891.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2,175,877,891.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2,083,965,241.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	1,043,582,265.75
210101	Үндсэн цалин	0.00	677,640,312.61
210102	Нэмэгдэл	0.00	294,155,976.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	12,231,000.00
210104	Урамшуулал	0.00	59,554,976.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	138,016,223.54
210201	Тэтгэврийн даатгал	0.00	105,923,011.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	8,501,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	6,800,999.85
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,369,704.64
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	15,421,308.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	146,192,631.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	18,933,036.00
210302	Түлш, халаалт	0.00	115,480,333.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	11,779,262.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	44,783,443.00
210401	Бичиг хэрэг	0.00	9,552,351.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	21,455,156.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2,463,556.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	1,317,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	9,995,380.00
2105	Нормативт зардал	0.00	461,435,041.01

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	354,986,367.01
210502	Хоол, хүнс	0.00	83,850,424.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	22,598,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	77,462,111.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,690,200.00
210604	Урсгал засвар	0.00	75,771,911.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	3,239,400.00
210702	Дотоод албан томилолт	0.00	3,239,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	45,622,104.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	41,666,030.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	150,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	3,479,099.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	123,632,022.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	111,132,022.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	91,912,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	90,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	85,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,012,650.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,012,650.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.00	660,359,466.35
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.00	660,359,466.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	757,270,416.00	1,672,335,074.33	-1,736,973,603.60	692,631,886.73
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,736,973,603.60	692,631,886.73
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	660,359,466.35	660,359,466.35
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,076,614,137.25	1,352,991,353.08

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	2,174,652,857.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	2,174,652,857.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,145,578,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	1,145,578,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	815,024,933.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,356,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	779,724,933.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	33,944,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	151,477,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	151,477,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	62,571,424.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	62,571,424.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	2,093,295,852.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2,093,295,852.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2,001,383,202.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	1,043,582,265.75
210101	Үндсэн цалин	0.00	677,640,312.61
210102	Нэмэгдэл	0.00	294,155,976.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	12,231,000.00
210104	Урамшуулал	0.00	59,554,976.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	138,016,223.54
210201	Тэтгэврийн даатгал	0.00	105,923,011.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	8,501,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	6,800,999.85
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,369,704.64
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	15,421,308.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	143,179,500.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	18,933,036.00
210302	Түлш, халаалт	0.00	112,467,202.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	11,779,262.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	46,658,497.00
210401	Бичиг хэрэг	0.00	9,512,170.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	22,628,421.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2,463,556.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	3,677,140.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	8,377,210.00
2105	Нормативт зардал	0.00	488,442,000.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	366,382,500.30
210502	Хоол, хүнс	0.00	99,059,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	23,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	80,074,311.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,690,200.00
210604	Урсгал засвар	0.00	78,384,111.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	3,239,400.00
210702	Дотоод албан томилолт	0.00	3,239,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	45,691,005.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	41,666,030.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	160,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	87,775.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	150,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	3,548,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	91,912,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	90,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	85,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,012,650.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,012,650.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	81,357,004.41
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	77,315,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	77,315,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	77,315,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	77,315,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-77,315,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	4,041,304.41
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,041,304.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,362,511,900.00	1,355,586,619.59	-6,925,280.41	99.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,362,511,900.00	1,355,586,619.59	-6,925,280.41	99.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,357,011,900.00	1,350,086,619.59	-6,925,280.41	99.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	850,124,800.00	845,448,712.75	-4,676,087.25	99.45
210101	Үндсэн цалин	526,709,600.00	479,506,759.61	-47,202,840.39	91.04
210102	Нэмэгдэл	241,791,600.00	294,155,976.89	52,364,376.89	121.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,091,600.00	12,231,000.00	-1,860,600.00	86.80
210104	Урамшуулал	67,532,000.00	59,554,976.25	-7,977,023.75	88.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,766,800.00	112,855,112.54	-1,911,687.46	98.33
210201	Тэтгэврийн даатгал	80,761,900.00	80,761,900.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,501,200.00	8,501,200.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,801,000.00	6,800,999.85	-0.15	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,700,200.00	1,369,704.64	-330,495.36	80.56
210205	Эрүүл мэндийн даатгал	17,002,500.00	15,421,308.05	-1,581,191.95	90.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,179,500.00	143,179,500.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	16,675,000.00	18,933,036.00	2,258,036.00	113.54
210302	Түлш, халаалт	107,138,100.00	112,467,202.00	5,329,102.00	104.97
210303	Цэвэр, бохир ус	19,366,400.00	11,779,262.00	-7,587,138.00	60.82
2104	Хангамж, бараа материалын зардал	35,100,000.00	35,100,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	5,100,000.00	5,032,170.00	-67,830.00	98.67
210402	Тээвэр, шатахуун	18,000,000.00	18,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,390,690.00	-9,310.00	99.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,600,000.00	3,677,140.00	77,140.00	102.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	142,000,000.00	141,999,999.30	-0.70	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,000,000.00	105,999,999.30	-0.70	100.00
210502	Хоол, хүнс	18,000,000.00	18,000,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,000,000.00	18,000,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,628,200.00	51,624,320.00	-3,880.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,600,000.00	9,596,200.00	-3,800.00	99.96
210604	Урсгал засвар	42,028,200.00	42,028,120.00	-80.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,281,400.00	2,980,000.00	-301,400.00	90.81
210702	Дотоод албан томилолт	3,281,400.00	2,980,000.00	-301,400.00	90.81

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,431,200.00	4,398,975.00	-32,225.00	99.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	562,000.00	562,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	160,000.00	160,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	87,775.00	-32,225.00	73.15
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,360,000.00	3,360,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500,000.00	12,500,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500,000.00	12,500,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,362,511,900.00	1,359,627,924.00	-2,883,976.00	99.79
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,145,578,800.00	1,145,578,800.00	0.00	100.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,145,578,800.00	1,145,578,800.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	151,477,700.00	151,477,700.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	151,477,700.00	151,477,700.00	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,455,400.00	62,571,424.00	-2,883,976.00	95.59
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	65,455,400.00	62,571,424.00	-2,883,976.00	95.59
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,041,304.41	4,041,304.41	#DIV/0!
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	123.00	123.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61.00	61.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	45.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61.00	61.00	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	61.00	61.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815,024,933.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,028,233.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,615,583.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,133,553.00
210101	Үндсэн цалин	198,133,553.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,161,111.00
210201	Тэтгэврийн даатгал	25,161,111.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,558,497.00
210401	Бичиг хэрэг	4,480,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,628,421.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	72,866.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,377,210.00
2105	Нормативт зардал	346,442,001.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	260,382,501.00
210502	Хоол, хүнс	81,059,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,768,991.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,413,000.00
210604	Урсгал засвар	36,355,991.00
2107	Томилолт, зочны зардал	259,400.00
210702	Дотоод албан томилолт	259,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,292,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,104,030.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	188,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,412,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	85,400,000.00
2133	Олгосон санхүүжилт шилжүүлэг	1,012,650.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,012,650.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	67,996,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	67,996,700.00
223001	Бусад хөрөнгө	67,996,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	815,024,933.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,024,933.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,356,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	779,724,933.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,944,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт болон зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн зорилго нь *“Мэргэжилтнээ дэмжсэн үйлчлүүлэгчээ хүндэтгэсэн тусламж үйлчилгээг орчин үеийн нотолгоонд тулгуурлан эмчилгээ зөвлөгөөг хариуцлагатай ээлтэй тэгш хүртээмжтэй үзүүлэх”*-д оршино.

Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т *“Сум, тосгоны эрүүл мэндийн төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна”* гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.
- ЭМДҮЗ-ын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон бусад зардлыг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус ЭМТ-ийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болон шууд захирагчийн зүгээс дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1,318,344.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,183.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **9,228.4** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,606.7 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		4,041.3	4,041.3
Авлага		569,522.0	569,522.0
Урьдчилгаа			
Бараа материал	18,270.7	99,920.7	81,650.0
Үндсэн хөрөнгө	674,361.2	689,729.8	15,368.6
Нийт хөрөнгө	692,631.9	1,363,213.8	670,581.9
Өр төлбөр		10,222.4	10,222.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	692,631.9	1,352,991.4	660,359.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	692,631.9	1,363,213.8	670,581.9

Мөнгөн хөрөнгө данс 4,041.3 мянган төгрөг болж өссөн нь тайланд онд төрийн сангийн харилцах дансанд үлдсэн 4,041.3 мянган төгрөгөөс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 569,522.0 мянган төгрөг болж өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих Ковид-19 цар тахлын санхүүжилтийн 1,312,501.4 мянган төгрөгөөс 742,979.4 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож 569,522.0 мянган төгрөгийн дутуугаар татаас, санхүүжилтийн авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 99,920.7 мянган төгрөг болж 81,650.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 616,899.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон сумын ЗДТГ-аас 2,100.0 мянган төгрөг, ОНОМ сангаас 2,269.0 мянган төгрөг, Сэлэнгэ Нэгдсэн Эмнэлгээс 1,331.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн газраас 37,176.8 мянган төгрөгийн бараа материал зэрэг нийт 42,877.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, байгууллагын үйл ажиллагаанд 578,127.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,717,791.4 мянган төгрөг болж өмнөх оноос 126,500.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамнаас 8,532.1 мянган төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газраас 29,167.8 мянган төгрөг, Эмэгтэйчүүдийн холбооноос 8,849.5 мянган төгрөг, хувь хүнээс 2,635.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр автокалаб, дефиблятор, яаралтай тарианы тэргэнцэр, термостат зэрэг 69,072.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, барианы ор, цахилгаан

соронзон төөнүүр, цахилгаан зүүний аппарат зэрэг 8,243.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авснаас тус тус шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,352,991.4 мянган төгрөг болж 660,359.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1.600,858.8 мянган төгрөгөөр буюу 129.5 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 70,947.9 мянган төгрөгөөр, санхүүжилтийн орлого 79,858.1 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 750,001.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих орлого 151,477.7, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 551,075.4 мянган төгрөгөөр тус тус өссөн, үндсэн үйл ажиллагааны орлого 2,501.4 мянган төгрөгөөр буурсан зэргээс тус тус шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 860,740.3 мянган төгрөгөөр буюу 65.4 хувиар өссөн байна. Энэ нь Ковид-19 цар тахлын Эрүүл мэндийн даатгалын сангаас 719,500.9 санхүүжилт ирснээс шалтгаалж цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол, хүнс, нормын хувцас, зөөлөн эдлэл, урсгал засвар зэрэг зардлууд өссөнөөс голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,387,534.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 30,022.3 мянган төгрөгөөр бууруулж, 1,357,511.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн “Сайхан сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолоор тодотгож, урсгал засварын зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр өсгөж, **1,362,511.9** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Эмнэлгийн тусламж үйлчилгээ, Ковид зэрэг 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,362,511.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,145,578.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 65,455.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 151,477.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1,145,578.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 62,571.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 151,477.7 мянган төгрөг зэрэг нийт 1,359,627.9 мянган төгрөгийн санхүүжилт авч

урсгал үйл ажиллагаанд 1,355,586.6 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 4,041.3 мянган төгрөг дансны үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас ковидын хэвтэн эмчлүүлэгчид болон вакцинд зарцуулах 681,087.4 мянган төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газраас илүү цагийн хөлс 97,677.5 мянган төгрөг, иргэн аж ахуй нэгжээс хандив 1,356.0 мянган төгрөг, 2020 оны татан төвлөрүүлсэн мөнгөний буцаалт 960.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 33,944.0 мянган төгрөг зэрэг нийт 815,024.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, цалин шимтгэлийн зардалд 223,294.6 мянган төгрөг, нормативт зардалд 346,442.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 85,400.0 мянган төгрөг, бусад зардалд 159,888.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон **589,036.2** мянган төгрөгийн анхны өртөгтэй, 238 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 сарын 29-ний өдрийн А/540 дугаар “Журам, шалгуур үзүүлэлт, жагсаалт батлах тухай” тушаалын дагуу сум дундын эмнэлэг нэртэй ажиллаж байсан дээрх эмнэлгийн санхүүжилтийг 2021 оноос эхлэн орон нутгийн төсөвт шилжүүлсэн байна.
- Сарын ажлын хоногийг тогтмол 176 цагаар тооцсоноос /1 цагт ногдох хөлсийг багаар тооцсон / ажилтнуудын илүү цагийн хөлсийг зөрүүтэй бодож, олгосон байна. Иймээс сар бүрийн ажлын цагийг үнэн зөв, бодитоор тооцсоны үндсэн дээр илүү цагийн хөлсийг олгож байх нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 22 төрлийн 175 мэдээллээс 166 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 260.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,218.5 мянган төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	260.3	1	260.3	100.0
Албан шаардлага	1	2,218.5	1	2,218.5	100.0
Зөвлөмж	2	2,772.2	2	2,772.2	100.0
Нийт дүн	4	5,251.0	4	5,251.0	100.0

/мянган төгрөг/

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **246,953.7** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 10,709.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,428.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 4,902.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 229,912.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- Тус байгууллагын төрийн сангийн дансан дахь үлдэгдэл **4,041.3** мянган төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан байсныг санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулав.
- Бараа материалын тайланд **4,080.0** мянган төгрөгийн орлого, зарлагыг дутуу тайлагнасныг залруулав.
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг **2,588.2** мянган төгрөгөөр дутуу тооцсоныг нөхөн тооцуулж, санхүүгийн тайланд залруулга хийв.

4.2 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас нэр бүхий 3 ажилтны ажилласан цагийг илүү тооцон 455.1 мянган төгрөгийн цалин, эмнэлгийн даргад 973.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлс / *хоногт 24 цаг ажилласнаар* / зэрэг нийт **1,428.9** мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ажил олгогчийн шийдвэргүйгээр 8 албан хаагчид **1,782.0** мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх "*Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг... ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна*" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "*Нийцтэй бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, зайлшгүй тохиолдолд ажил олгогчийн шийдвэрийн дагуу холбогдох хувь хэмжээгээр тооцон урамшуулал олгож байх албан шаардлага хүргүүлэх.

2. Төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт санхүүжилтийн НДШ-ийн зардлаас үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардалд **3,120.9** мянган төгрөгийг хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйл "*Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6 дахь "*... дээд шатны төсвийн захирагчийн*

зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцтэй бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авч төсөвт зохицуулалт хийлгэж байх, гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Зардлын данстай холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** Жилийн эцэст НДШ, ХХОАТ-ын тооцоог холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж өр төлбөр, авлагагүйгээр баталгаажуулсан хэдий ч амралтын цалингаас тооцох НДШ, ХХОАТ-ыг зөрүүтэй тооцоолсноос **1,933.0** мянган төгрөгийн авлага үүсэж болзошгүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчиж байгаа ба “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 2022 оны эхний хагас жилд багтаан холбогдох байгууллагуудтай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулах.

2. **Зардлын данстай холбоотой асуудал**

2.1. **Илрүүлэлт:** Ажилтнуудын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр нийт **5,144.9** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон байна.

2.2. **Өгсөн зөвлөмж:** Дээрх зөрчил нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэхүү журмын 4-т заасан **шалгуур үзүүлэлтийн дагуу** албан тушаалын сарын үндсэн цалингийн 10-25 хувиар тооцож, **сар бүр** олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн ба “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсний үндсэн дээр ур чадварын нэмэгдэл олгож байх.

3. **Анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

3.1. **Илрүүлэлт:** Тайлант онд **222,834.5** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

3.2. **Өгсөн зөвлөмж:** Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

4.1. **Илрүүлэлт:** Шилэн дансанд мэдээлбэл зохих 7 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

4.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сайхан сумын Эрүүл мэндийн төв	10	246,953.7	3	10,709.5	1	1,428.9	2	4,902.9	4	229,912.4